



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 0/314

Хэрлэн сум

Хэнтий аймгийн Скаутын зөвлөлд  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Скаутын зөвлөлөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу “Байгаль дахь сургалтын цогцолбор бааз” байгуулах зардалд 3,350,000 (гурван сая гурван зуун тавин мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн байгууллага иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ